

АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/219/-НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2022 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор Ж.Мөнгөншагай Утас: 90909190 Цахим хаяг: Mungunshagaij@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	8
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгалаа.....	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	10
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	11
4. Аудитын илрүүлэлт	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар



**АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ч.БАТНАЙРАМДАЛ
ТАНАА

2022.02.17 № 17
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	28,554,825.63	16,438,432.00
2	МӨНГӨН ХӨРӨНГӨ	28,550,659.15	16,438,432.00
3	Банкинд байгаа бэлэн мөнгө	28,550,659.15	16,438,432.00
4	Төгрөг	28,550,659.15	16,438,432.00
5	Арилжааны банк дахь харилцах	28,550,659.15	16,438,432.00
6	АВЛАГА	4,166.48	-
7	Бусад авлага	4,166.48	-
8	Байгууллагаас авах авлага	4,166.48	-
9	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	28,554,825.63	16,438,432.00
10	НИЙТ ӨР ТӨЛБӨР	30,097,010.00	15,952,400.00
11	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	30,097,010.00	15,952,400.00
12	Өглөг	30,097,010.00	15,952,400.00
13	Бусад өглөг	30,097,010.00	15,952,400.00
14	Хувь хүмүүст төлөх өглөг	30,097,010.00	15,952,400.00
15	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-1,542,184.37	486,032.00
16	Засгийн газрын хувь оролцоо	-1,542,184.37	486,032.00
17	Хуримтлагдсан үр дүн	-1,542,184.37	486,032.00
18	Өмнөх үеийн үр дүн	23,138,300.24	7,117,125.63
19	Тайлант үеийн үр дүн	-24,680,484.61	-6,631,093.63
20	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	28,554,825.63	16,438,432.00

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	15,317,611,667.16	6,000,389,309.14
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,717,077.16	8,842,309.14
3	Нийтлэг татварын бус орлого	7,717,077.16	8,842,309.14
4	Хүүгийн орлого	7,717,077.16	19,634.74
5	Бусад орлого		8,822,674.40
6	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,309,894,590.00	5,991,547,000.00
7	Улсын төвлөрсөн төсвөөс	15,309,894,590.00	5,991,547,000.00
8	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	15,342,292,151.77	6,007,020,402.77
9	УРСГАЛ ЗАРДАЛ	15,342,292,151.77	6,007,020,402.77
10	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,055,000.00	29,819,300.00
11	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,055,000.00	29,819,300.00
12	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,400,000.00	28,168,000.00

13	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,655,000.00	1,651,300.00
14	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,312,237,151.77	5,977,201,102.77
15	Бусад урсгал шилжүүлэг	15,258,756,230.00	5,933,197,022.39
16	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	15,258,756,230.00	5,933,197,022.39
17	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	53,480,921.77	44,004,080.38
18	Төвлөрүүлэх шилжүүлэг	53,480,921.77	44,004,080.38
19	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(24,680,484.61)</u>	<u>(6,631,093.63)</u>
20	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(24,680,484.61)</u>	<u>(6,631,093.63)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

№	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл			23,138,300.24		23,138,300.24
2	Тайлант үеийн үр дүн			-24,680,484.61		-24,680,484.61
3	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
4	2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	0.00	0.00	-1,542,184.37	0.00	-1,542,184.37
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00		0.00
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	7,117,125.63	0.00	7,117,125.63
7	Тайлант үеийн үр дүн			-6,631,093.63		-6,631,093.63
8	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	486,032.00	0.00	486,032.00

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

№	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>15,333,080,097.16</u>	<u>6,027,085,941.23</u>
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,185,507.16	35,538,941.23
3	Нийтлэг татварын бус орлого	23,185,507.16	35,538,941.23
4	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,717,077.16	19,634.74
5	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,717,077.16	19,634.74
6	Бусад орлого	15,468,430.00	35,519,306.49
7	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	15,309,894,590.00	5,991,547,000.00
8	Улсын төвлөрсөн төсвөөс	15,309,894,590.00	5,991,547,000.00
9	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,309,894,590.00	5,991,547,000.00
10	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>15,365,160,461.77</u>	<u>6,039,198,168.38</u>
11	УРСГАЛ ЗАРДАЛ	15,365,160,461.77	6,039,198,168.38
12	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	30,055,000.00	29,192,900.00

13	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,055,000.00	29,192,900.00
14	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,400,000.00	27,541,600.00
15	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,655,000.00	1,651,300.00
16	Бусад урсгал шилжүүлэг	15,281,624,540.00	5,966,001,188.00
17	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	15,281,624,540.00	5,966,001,188.00
18	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	53,480,921.77	44,004,080.38
19	Төвлөрүүлэх шилжүүлэг	53,480,921.77	44,004,080.38
20	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(32,080,364.61)</u>	<u>(12,112,227.15)</u>
21	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	=
22	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(32,080,364.61)	(12,112,227.15)
23	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	60,635,190.24	28,550,659.15
24	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	28,550,659.15	16,438,432.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөг/

№	Үзүүлэлт	төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,991,547,000.00	5,968,501,622.39	23,045,377.61	99.6
2	УРСГАЛ ЗАРДАЛ	5,991,547,000.00	5,968,501,622.39	23,045,377.61	99.6
3	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,991,547,000.00	5,968,501,622.39	23,045,377.61	99.6
4	Бусад урсгал шилжүүлэг	5,991,547,000.00	5,968,501,622.39	23,045,377.61	99.6
4	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	5,991,547,000.00	5,968,501,622.39	23,045,377.61	99.6
6	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,991,547,000.00	5,991,547,000.00	0.00	100
7	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,991,547,000.00	5,991,547,000.00	0.00	100
8	Улсын төсвөөс санхүүжих	5,991,547,000.00	5,991,547,000.00	0.00	100
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		28,550,659.15	-28,550,659.15	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		16,438,432.00	-16,438,432.00	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Архангай аймгийн Халамжийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Мөнгөншагай гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 35 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Халамжийн сан нь Нийгмийн халамжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Тэтгэвэр, тэтгэмжийн сангийн хөрөнгийг зөвхөн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид зарцуулна”, 8.2 “Нийгмийн үйлчилгээний сангийн хөрөнгийг дараах үйлчилгээ, үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна.” гэж заасны дагуу харьяалах нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харьяа сан юм.

Тус сан нь тайлант онд “Хүн амын бүлгийн хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйлчилгээ, арга хэмжээг хэрэгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламжийг олгох ажлыг зохион байгуулах” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Тайлант хугацаанд сангийн үйл ажиллагаатай холбоотой санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Халамжийн сангийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Халамжийн сангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, сангийн үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Хөдөлмөр Халамжийн үйлчилгээний газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хариуцсан албан тушаалтан нь сангийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийжээ. Мөн аймгийн Мэргэжлийн хяналтын газраас тус сангийн хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний 2021 оны 1-3 дугаар сарын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Архангай аймгийн Халамжийн сангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 6,099.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 61.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 42.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Тус сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн оны эхний үлдэгдлээс 12.1 сая төгрөгөөр буюу 42.4 хувиар буурч материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүү байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/	
			Өөрчлөлт	Хувь
Мөнгөн хөрөнгө	28.6	16.4	(12.1)	-42.4
Нийт хөрөнгө	28.6	16.4	(12.1)	-42.4
Богино хугацаат өр төлбөр	30.1	15.9	(14.1)	-47.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	28.6	16.4	(12.1)	-42.4

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 12.1 хувиар буурсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс нь 28.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй бөгөөд тайлант онд 12.1 сая төгрөгөөр буурч 16.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь өмнөх оны өр төлбөрийг барагдуулсантай холбоотой байна.

- Тайлант онд Халамжийн сан нь авлагагүй ажилласан бөгөөд өмнөх оны авлагыг 100 хувь төвлөрүүлсэн байна.
- Цэвэр хөрөнгө өмчийн дүн буурсан нь тайлант хугацааны мөнгөн хөрөнгө 12.1 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмөнх он	Тайлант он	Өөрчлөлт
0	1	2	3=2-1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	15,317.6	6,000.4	-9,317.2
Нийтлэг татварын бус орлого	7.7	8.8	1.1
Улсын төвлөрсөн төсвөөс	15,309.9	5,991.5	-9,318.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	15,2888	5,963.0	-9,325.8
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	53.5	44.0	-9.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	15,342.3	6,007.0	-9,335.3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-24.7	-6.7	18.0

- Тайлант онд үр дүнгийн тайлангийн улсын төсвийн орлого, зарцуулалт эрс буурсан нь 2021 оны 5, 11 дүгээр саруудаас халамжийн сангийн зарим нэр төрлийн үйлчилгээ нь Сангийн яамнаас шууд санхүүжигдэн иргэдийн харилцах дансруу шилжүүлдэг болсонтой холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Халамжийн сан нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 11,282.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсөв захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг нийт 192.4 сая төгрөгөөр өсгөж, нийт зардлыг 11,474.9 сая төгрөгөөр хянаж баталсан. Энэ нь ковид-19 цар тахлын улмаас халамжийн тэтгэвэрийн хэмжээг 0.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн олгох болсонтой холбоотой байна. Харин 2021 оны 5 дугаар сараас халамжийн тэтгэвэр, 11 дүгээр сараас халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, амьжиргааг дэмжих мөнгөн тусламжийн санхүүжилтийг Сангийн яамнаас иргэдийн арилжааны банкин дахь харилцах дансанд шууд шилжүүлдэг болсонтой холбоотой сангийн төсөв 5,483.4 сая төгрөгөөр буурч төсвийн хуваарьт өөрчлөлт орсон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхэд 5,991.5 сая төгрөгийн төсөв батлагджээ. Халамжийн сан нь 28.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй бөгөөд улсын төсвөөс 5,991.5 сая төгрөгийн, хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээнээс 2019, 2020 онд иргэдэд олгосон боловч тухайн иргэд аваагүй арилжааны банкин дахь цахим дансны үлдэгдэл 8.8 сая төгрөгийн, нийт 6,000.3 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлснээс 5,968.5 сая төгрөгийг тэтгэвэр, тэтгэмжид зарцуулан, бусад орлого 8.6 сая, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 34.5 сая, хүүгийн орлого 0.9 сая, нийт 44.0 сая төгрөгийг төвлөрүүлсэн бол 16.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Халамжийн сангийн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалан нэмэлт санхүүжилтийн дансгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлангийн жилд тус сангийн төсөв захирагчаар Ч.Батнайрамдал нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2021 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн Б/20 тушаалаар даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдон ажиллаж байна.

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 411 дүгээр тогтоолын дагуу ХНХЯ-ны дэргэдэх салбар зөвлөлөөс аймгийн ХХҮГ-ын даргын сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулах ажлыг эхлүүлсэн байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан стратегийн зорилтуудыг хангахад чиглэсэн 15 үндсэн зорилтын хүрээнд 75 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 83.3 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 5,991.5 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 18,360 иргэнд 5,968.5 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг олгож, 99.6 хувийн биелэлттэй байна.

Тус сан нь Ковид-19 цар тахалтай холбоотой халамжийн тэтгэвэрийн хэмжээг 0.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, мөн 2021 оны 5 дугаар сараас халамжийн тэтгэвэр, 11 дүгээр сараас халамжийн нөхцөлт мөнгөн тэтгэмж, амьжиргааг дэмжих мөнгөн тусламжийн санхүүжилтийг Сангийн яамнаас иргэдийн арилжааны банкин дахь харилцах дансанд шууд шилжүүлэн олгодог болсон байна.

Халамжийн сангийн онцлогоос шалтгаалан Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах боломжгүй байна. Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэл гаргаж ирүүлсэн.

Тайлант онд Халамжийн сан нь 8 ажил үйлчилгээ үзүүлэхээр 5,991.5 сая төгрөгийн санхүүжилтийг улсын төсвөөс авч нийт 18,360 иргэнийг халамжийн тэтгэвэр, тэтгэмжинд хамруулан 5,968.5 сая төгрөгийг олгосон байна .

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгалаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Халамжийн сан нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 149 мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Энэ нь Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй тул зөвлөмж өгөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудалгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар илрүүлэлт гараагүй болно.